



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 823

Улаанбаатар хот

«Дуудлага худалдааг дахин зохион байгуулах» зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.4 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дугаар тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Монголросцветмет" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 315,362,448.32 (гурван зуун арван таван сая гурван зуун жаран хоёр мянга дөрвөн зуун дөчин найман төгрөг гучин хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, 288,262,828.50 (хоёр зуун наян найман сая хоёр зуун жаран хоёр мянга найман зуун хорин найман төгрөг тавин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий илчит тэрэгний хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул нээлттэй дуудлага худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2."Монголросцветмет" төрийн өмчит үйлдвэрийн газрын дарга Б.Мөнхбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захирамжын актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу үйлдвэрийн газарт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Хөрөнгийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх;

123006879

37-r_huraldaan.docx

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 26 ны өдрийн
823 дугаар тогтоолын хавсралт

"МОНГОЛПРОСЦЕВМЕТ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Суудлын автомашин марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтанд орсон он	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ын 2020 оны 76 тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)
1	Илчит тэрэг, ТЭМ2У-1093	1972/1972	315,362,448.32	288,262,828.50	27,099,619.82	30,000,000.00	15,000,000.00
Нийт дүн			315,362,448.32	288,262,828.50	27,099,619.82	30,000,000.00	15,000,000.00
			(гурван зуун арван таван сая гурван зуун жаран хоёр мянга дөрвөн зуун дөчин найман төгрөг гучин хоёр мөнгө)	(хоёр зуун наян найман сая хоёр зуун жаран хоёр мянга найман зуун хорин найман төгрөг тавин мөнгө)	(хорин долоон сая ерэн есөн мянга зургаан зуун арван есөн төгрөг наян хоёр мөнгө)	(гучин сая)	(арван таван сая)